



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/95

Мөрөн сум

Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг  
үүрэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2, 48.3, 48.4, 49 дүгээр зүйлийн 49.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.4, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын хэрэгжүүлэх чиг үүргийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү захирамжийн хавсралтад заасан чиг үүргийг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнаж ажиллахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН

